

**“БАРИЛГЫН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН ХЭМЖЭЭГ ТОГТМОЛ ТООЦООЛОХ
МЭДЭЭЛЛИЙН САНГ ХӨТЛӨХ, ХӨГЖҮҮЛЭХ, СЕРВЕРИЙН НАЙДВАРТАЙ
АЖИЛЛАГААНД ТОГТМОЛ ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ” -ЫН ТАНИЛЦУУЛГА**

1. Журам боловсруулах эрх зүйн үндэслэл

- Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг;
- Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журмын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэв.

2. Журам боловсруулах шаардлага, тулгамдаж буй асуудал

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээрт Монгол Улс 2019 онд нэгдэж 2030 онд Хүлэмжийн хийг 22,7% бууруулах амлалт өгсөн байна.

Үүнээс барилгын салбар 2030 онд 830,000 тн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилттой.

Барилгаас ялгарч буй хүлэмжийн хийг тооцоолоход “Барилгын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тооцох аргачлал” /БД 23-105-20/, “Барилгын хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцох аргачлал” /БД 25-106-20/ норм, нормативын баримт бичиг, 2006 онд батлагдсан “Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх засгийн газар хоорондын зөвлөл”(IPCC 2006) ашиглагдах бөгөөд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК, “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ, Ус дулаан дамжуулах төв, “Таван толгой түлш” ХК, “Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ-аас мэдээлэл солилцох, мэдээлэл хөтлөх шаардлага үүссэн.

Иймд дээрх байгууллагуудыг Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн санд мэдээлэл солилцох, мэдээлэл хөтлөх эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна.

3. Журам батлагдсанаар дараах үр дүн гарна. Үүнд:

- Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн санг тогтмол хөтлөх;
- Мэдээлэл солилцох, хөтлөх үйл ажиллагааг хянах;
- Барилгаас ялгарах хүлэмжийн хийн ялгарлыг бүрэн тооцоолох;
- Тайлан мэдээ бүрэн боловсруулах;
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах



ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

_____оны _____сарын _____өдөр

Дугаар _____

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журмын 3.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Барилгын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тогтмол тооцоолох мэдээллийн санг хөтлөх, хөгжүүлэх, серверийн найдвартай ажиллагаанд тогтмол хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангуулахад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (_____) -д даалгасугай.

3. Эрхлэх чиг үүргийнхээ хүрээнд уг журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төрийн байгууллагууд, сервис холболтоор мэдээлэл солилцогч болон мэдээлэл хөтөлж буй байгууллагуудад тус тус үүрэг болгосугай.

САЙД

**БАРИЛГЫН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН ХЭМЖЭЭГ ТООЦООЛОХ
МЭДЭЭЛЛИЙН САНГ ХӨТЛӨХ, ХӨГЖҮҮЛЭХ, СЕРВЕРИЙН НАЙДВАРТАЙ
АЖИЛЛАГААНД ТОГТМОЛ ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдсон болон төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбогдоогүй хатуу түлш нүүрс зэрэг энгийн галлагаатай барилгын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тооцох мэдээллийн сан (www.ghgconstruction.gov.mn) (цаашид “Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн сан” гэх) - г хөтлөх, мэдээлэл солилцох, боловсруулах, нийтэд мэдээлэх, хөгжүүлэх, хадгалах, хамгаалах харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн сан нь тооцооллоо “Барилгын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тооцох аргачлал” /БД 23-105-20/, “Барилгын хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцох аргачлал” /БД 25-106-20/ норм, нормативын баримт бичиг, 2006 онд батлагдсан “Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх засгийн газар хоорондын зөвлөл”(IPCC 2006)-ийн дагуу гүйцэтгэхээр программчлагдсан байна.

1.3. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь нь Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн сангийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангана.

1.4. Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн санд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК, “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ, Ус дулаан дамжуулах төв холбогдох байгууллагууд хүлэмжийн хийн тооцоололд ашиглагдах анхдагч мэдээллээ сервис холболтоор ирүүлнэ.

1.5. Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн санг “Таван толгой түлш” ХК, “Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” ОНӨААТҮГ нь тухай бүр хөтөлнө.

Хоёр. Нэр томъёоны тайлбар

2.1. “Мэдээллийн сан” гэж мэдээллийг бүрдүүлэх, хөтлөх, хадгалах, удирдах, ашиглах боломжтой, шийдвэр гаргах, боловсруулах үйл ажиллагаанд хүний оролцоог хамгийн багаар шийдвэрлэсэн, автоматжуулсан тооцоололтой программ хангамжийг;

2.2. “Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн сан” гэж орон зайн мэдээлэлд суурилсан, барилга байгууламжийн хүлэмжийн хийн ялгарлын үзүүлэлтийг сервис холболтоор авч үнэн зөв тооцоолол хийх боломжтой, цахим хандалттай программ хангамжийг;

2.3. “Сервис холболт” гэж 2 ба түүнээс дээш мэдээллийн санг харилцан хамааралтай мэдээллээр, программчлалын хэлний тусламжтайгаар холбож, мэдээлэл солилцохыг;

2.4. “Сервис холболтын баримт бичиг” гэж мэдээллийн сан хооронд мэдээлэл солилцох боломжийг үүсгэсэн аль нэг программчлалын хэлээр бичигдсэн кодыг;

2.5. “Анхдагч мэдээлэл” гэж мэдээллийн санд анхлан бүртгэгдэж буй үнэн бодит мэдээллийг;

2.6. “Мэдээллийн сангийн архитектур” гэж мэдээллийн санг бүрдүүлж буй бүрэлдэхүүний дэлгэрэнгүй нэгтгэлийг;

2.7. “Мэдээллийн сангийн үйлдлийн бүртгэл” гэж Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтыг хэлнэ.

Гурав. Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн сангийн эрх

3.1. Мэдээлэл хариуцагчийг мэдээлэл зохицуулагч, мэдээлэл солилцогч, мэдээлэл анхлан хөтлөгч, мэдээлэл хөтлөгч, хэрэглэгч гэж ангилна;

3.2. Мэдээлэл зохицуулагч нь барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байх бөгөөд, хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн санд хандах эрхийн түвшинг тодорхойлж, нэвтрэх эрхийг бусад мэдээлэл хариуцагчид олгоно;

3.3. Мэдээлэл солилцогч нь энэ журмын 1.4-д заасан болон шаардлагатай бусад байгууллагууд байх бөгөөд, солилцож байгаа мэдээллийн агууламж нэмэгдэх тохиолдолд тухай бүр сервис холболтын баримт бичиг ирүүлнэ;

3.4. Мэдээлэл анхлан хөтлөгч нь энэ журмын 1.5-д заасан байгууллага байх бөгөөд тогтоосон хугацаанд мэдээллээ тогтмол шинэчилж хөтөлнө;

3.5. Мэдээлэл хөтлөгч нь барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байх бөгөөд сервис холболтоор ирж буй мэдээлэл, энэ журмын 3.4-д заасан байгууллагын хөтлөлтөд хяналт тавина;

3.6. Хэрэглэгч нь иргэн, аж ахуйн нэгж байх бөгөөд ХХЯ-ын мэдээллийн санд байршсан мэдээллийг ашиглах эрхтэй байна.

Дөрөв. Мэдээлэл солилцох, хөтлөх, боловсруулах, нийтэд мэдээлэх

4.1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь орон зайн мэдээлэл, “Цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь хэрэглэгчийн дугаар, тоолуурын заалт, хаяг, “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК, Ус дулаан дамжуулах төв нь ус дулаан дамжуулах төвийн байршил, тоолуурын заалт, “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ нь барилгын дугаар, байршил, тоолуурын заалтыг сервис холболтоор Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн санд ирүүлж мэдээлэл солилцоно.

4.2. Мөн Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн санд “Таван толгой түлш” ХК нь “Шахмал нүүрсэн түлш борлуулах цэг”-ээр худалдаанд гарсан түлшний мэдээлэл, “Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар” нь халаалтын зуухны ашиглаж буй нүүрсний зарцуулалтын мэдээллийг тогтмол ирүүлнэ.

4.3. Мэдээлэл хөтлөгч нь энэ журмын 4.1, 4.2-д заасан байгууллагын ирүүлсэн мэдээлэлд хяналт тавьж, мэдээлэл хөтөлж, боловсруулалт хийн тайланг хагас жил тутамд мэдээлэл зохицуулагчид хүргүүлнэ.

4.4. Энэ журмын 1.2-д заасан тооцооллын дагуу боловсруулагдсан мэдээллийг мэдээлэл хөтлөгч нь Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн сангаар нийтэд мэдээлнэ;

4.5. Мэдээлэл хөтлөгч нь Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн санг хөгжүүлэх саналыг жил бүр боловсруулна.

Тав. Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн сангийн хөгжүүлэлт

5.1. Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн сангийн архитектуртай заавал уялдуулах бөгөөд мэдээлэл зохицуулагч эсвэл программ хангамжийн мэргэжлийн хуулийн этгээд хөгжүүлэлтийг гүйцэтгэнэ.

5.2. Мэдээлэл зохицуулагч нь хөгжүүлэлт, сервис холболт, хэвийн ажиллагаа туршилт түүний хандалтын бодит цаг хугацаанд хяналт тавьж ажиллана.

5.3. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9, 4.1.10 дахь заалтын дагуу дүгнэлт гаргуулсан бусад байгууллагын мэдээллийн сантай сервис холболт хийнэ.

5.4. Сервис холболтоор мэдээлэл солилцохдоо энэ журмын 1.4, 1.5-д заасан байгууллагуудтай “Мэдээлэл солилцох, хамтран ажиллах гэрээ” байгуулсан байна.

5.5. Барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан /www.mcis.gov.mn/-тэй сервисээр мэдээлэл солилцдог байна.

5.6. Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн сан нь мэдээллийн сангийн үйлдлийн бүртгэлтэй байна.

Зургаа. Хадгалах хамгаалах

6.1. Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн сан нь “Үндэсний дата төв” УҮГ-т байрших бөгөөд нөөц хувь/back up/-ийг 7 хоногт 2 удаа хийнэ. Нөөц хувийн 2 дахь хувийг мэдээлэл зохицуулагч хадгална.

6.2. Мэдээлэл зохицуулагч нь мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана. Үүнд:

6.2.1. Эмзэг байдал, эрсдэлийг доторхойлох

6.2.2. Нууцлал, аюулгүй байдал алдагдсан гэж үзвэл шуурхай хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх;

6.2.3. Хөгжүүлэлтийг туршилтын орчинд гүйцэтгэх;

6.2.4. SSL шифрлэлт болон ашиглагдаж буй программ хангамжуудыг албан ёсны эрхтэй /лиценз/ хэрэглэх;

6.2.5. Нэвтрэх эрх хаагдсан, түдгэлзүүлсэн оролцогч талуудын мэдээллийн сангийн үйлдлийн бүртгэлийг устгахгүй, хадгална;

6.2.6. Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн сангийн үйл ажиллагаа, хөтлөлт, мэдээллийн сангийн үйлдлийн бүртгэл, хамгаалалтад жилд нэг удаа хяналт шинжилгээ үнэлгээ хийж үр дүнг оролцогч талуудад мэдээлэж, хариу арга хэмжээ авна;

6.2.7. Хүлэмжийн хийн ялгарлын мэдээллийн сангийн мэдээллийн санд Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9, 4.1.10-д заасны дагуу дүгнэлт гаргуулж, шаардлагатай үйл ажиллагааг зохион байгуулна.

Долоо. Хариуцлага

7.1. Мэдээллийн үнэн бодит байдлыг мэдээлэл хариуцагч хариуцна.

7.2. Энэхүү журмыг зөрчсөн мэдээлэл хариуцагч, иргэн, хуулийн этгээд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ;

_____ оОо _____